



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2016 оны 08 сарын 30 өдөр

Дугаар A/109

Улаанбаатар хот


**Ногоон байгууламжийн тооллого
явуулах тухай**

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9, 4 дүгээр хэсгийн 4.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн тооллогыг 2016 оны 09 дүгээр сарын 05-наас 09 дүгээр сарын 19-ний өдрүүдэд явуулахыг Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Т.Батбаяр/-т үүрэг болгосугай.

2.Ногоон байгууламжийн тооллого явуулах ажлын хэсгийг 1 дүгээр, тооллого хийх аргачлал, хөтлөх маягыг 2 дугаар, тооллого хийгдэх гудамж, цэцэрлэгийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тооллогын явц, ач холбогдол, үр дүнг хэвлэл мэдээллээр олон нийтэд сурталчлах, мод, сөөг, зүлэгт талбайн тооллогын дүнг хотын ногоон байгууламжийн мэдээллийн санд оруулах, ажлын хэсгийн тайланг Улаанбаатар хотын Ерөнхий менежерт 09 дүгээр сарын 30-ны дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Л.Баатарцогт/-т даалгасугай.

**ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ**  **Т.ГАНТӨМӨР**

УХА0501 9077367


Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 08 сарын 30 өдрийн
#109 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО ЯВУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч	Л.Баатарцогт	Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны Ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Д.Батцэцэг	Нийтийн Үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлийн ногоон байгууламжийн ахлах инженер Нийтийн Үйлчилгээний Улаанбаатар Нэгтгэлийн ойн инженер, техникч нар
	О.Мэндсайхан	Нийслэлийн ногоон байгууламжийн иргэний зөвлөл Төрийн бус байгууллагын тэргүүн
	Н.Эрдэнэбаяр	Далайн цалгиа Төрийн бус байгууллагын тэргүүн
	О.Золзаяа	Мөнх ногоон хэрэм хөдөлгөөн Төрийн бус байгууллагын тэргүүн Гудамж, цэцэрлэгүүдийг гэрээгээр хариуцан ажиллаж байгаа цэцэрлэгжилтийн хувийн хэвшлийн байгууллагуудын дарга, захирал, инженер, техникчид
Нарийн бичгийн дарга	Х.Уянга	Нийтийн Үйлчилгээний Улаанбаатар нэгтгэлийн Ногоон байгууламжийн албаны мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны... сарын... өдрийн
#1109-р тушаалын... хавсралт



НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ ТООЛОХ АРГАЧЛАЛ

Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн тооллогыг явуулахдаа дараах аргачлалыг баримтлана. Үүнд:

1. Навчит болон шилмүүст модыг тоолох

Гудамж, цэцэрлэгт ургаж байгаа моддыг тоолохдоо мод нэг бүрийг нэр төрлөөр нь ширхэгчлэн тоолно. Мөн тухайн объектод нөхөн тарих болон нэмж шинээр тарьж болох модны тоог нэр төрөлтэй нь тооцож гаргана.

2. Бут, сөөгийг тоолох

Бут, сөөгийг тоолохдоо -Нүхэнд ганцаараа дагнан ургаж байгаа монос, өрөл, долоогоно, хайлаас, агч, голт бор гэх мэтийн сөөгийг нүх бүрээр нь ширхэгчлэн тоолно.
-Бут хэлбэрээр багцалж нүхэнд тарьсан хайлаас, шар хуайс, тэхийн шээг, нохойн хошуу, монос, голт бор гэх мэт сөөгийг тоолохдоо 1 нүхэнд байгаа сөөгийг тоолж дундаж тоог гарган нийт нүхний тоогоор үржүүлж тоолно.
-Ургамлан хашлаганд тарьсан хайлаас, шар хуайс, тэхийн шээг, нохойн хошуу гэх мэтийн сөөгийг тоолохдоо 1 метрт байгаа сөөгний дундаж тоог гарган нийт уртаар нь үржүүлж тоолно.

Тооллогын гишүүд тухайн объектод нөхөн болон шинээр тарих шаардлагатай бут, сөөгний тоог мөн адил тооцож гаргана.

3. Зүлгийг тоолох

Зүлэгт талбайн хэмжээг гаргахдаа зүлэгний уртын хэмжээг өргөнөөр нь үржиж гаргана. Ингэхдээ албан ёсоор тавьсан автозам, явган хүний зам, инженерийн барилга, байгууламжийн хэмжээг хасч зүлэгний хэмжээг гаргана. Хүн, машины хөлөөр талхлагдсан албан бус зэрэг зам, хэсгийг зүлэгт талбайн хэмжээнд оруулж тооцно. Нэг ба олон наст цэцэг тарьсан талбайг зүлэгт талбайд тооцож тоолно. Зүлгийг тоолох явцдаа тухайн объектод нөхөн тарих шаардлагатай зүлэгний хэмжээг мөн тооцож гаргана.

Тооллогын гишүүд тооллогын дүнг 09 дүгээр сарын 23-ны өдөр Захирагчийн Ажлын албанд ирүүлж Хотын ногоон байгууламжийн санд байршуулна.

Маягт 1.

УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ,
ЦЭЦЭРЛЭГИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГЫН ДҮН.

..... оны.....сарын.....ны өдөр

Д/д	Гудамж, цэцэрлэгийн нэр	Зүлэгт талбай /м2/	Нөхөн тарих зүлэг /м2/	Навчит мод /ширхэг/			Бүгд /ш/	Нөхөн болон шинээр тарих мод /ш/	Шилмүүст мод /ширхэг/				Бүгд /ш/	Нөхөн болон шинээр тарих мод /ш/
				Улиас	Хус	Бусад			Шинэс	Гацуур	Нарс	Бусад		
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1.	Энхтайваны өргөн чөлөө													
	Нийт дүн													

Тооллогын гишүүд:...../ /
/ /
/ /

Маягт 2.

.....оны.....сарын.....ны өдөр

д/д	Гудамж,цэцэрлэгийн нэр	Бүт сөөг /ширхэг/													
		хайлаас	Шар хуайс	Долоо гоно	өрөл	гүйлс	Буйлс	Нохойн хошуу	монос	Тэхийн шээг	Голт бор	агч	Бусад	Бүгд /ширхэг/	Нөхөн шинээр тарих сөөг ширхэг болон
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1.	Энхтайваны өргөн чөлөө														
2.															
3.															
4.															
5.															
6.															
11.															
12.															
	Нийт дүн /ширхэг/														

Тооллогын гишүүд:...../ /
/ /
/ /
/ /

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2016 оны 08 сарын 25 өдрийн
 А/1109-р тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ,
 ЦЭЦЭРЛЭГИЙН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТООЛЛОГО ХИЙГДЭХ
 ГУДАМЖ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЖАГСААЛТ

д/д	Гудамж, цэцэрлэгүүдийн нэр	Тооллого хийх байгууллагууд
1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9. 10. 11. 12. 13. 14. 15. 16. 17. 18. 19. 20. 21. 22. 23. 24.	Чингэсийн өргөн чөлөө /Төв шуудангаас Энхтайваны гүүр, гүүрнээс Яармагийн Туулын гүүр хүртэлх зам дагууд/ Цэрэндоржийн гудамж Их Монгол Улсын гудамж Олимпын гудамж Нийслэл хүрээ өргөн чөлөө Засгийн газрын ордны зүүн, баруун талын гудамж /Их сургууль, Сүхбаатарын гудамж/ Нарны замын тусгаарлах зурвас/ Нарны гүүрээс Наран туул зах хүртэл/ Энхтайваны болон Нарны гүүр, Зайсан,Маршалын гүүр, Баянзүрх, Яармагийн гүүрний цэцэгжүүлсэн талбай Замын уулзварууд, аюулгүйн тойрог, замын тусгаарлах зурвасуудын цэцэгтэй хэсэг Хотын төв талбайн зүлэгтэй хэсгүүд Хөшөө, дүүргийн өндөрлөг орчим Жамьян гүний гудамж Гэндэнгийн гудамж Их тойруу Зайсан /Тэмээтэй уулзвараас урагш ХААИС-ын хойд уулзвар/ И Тэ Жү –ний цэцэрлэг Бурхан багшийн цэцэрлэг Ээрмэлийн үйлдвэрийн орчим Намянжугийн гудамж Наадамчдын зам Чингис хаан нисэх буудлын орчмын зам, бичил цэцэрлэг Чингисийн хүрээ орох зам Дүнжингаравын зам /Богд уулын арын зам - 16км/ Төв цэнгэлдэх хүрээлэн орчим	Нийслэлийн ногоон байгууламжийн иргэний зөвлөл Төрийн бус байгууллага, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл, цэцэрлэгжилтийн мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг
1. 2. 3. 4. 5. 6. 7. 8. 9.	Баянзүрх дүүрэг Энхтайваны өргөн чөлөө /Арслантай гүүрнээс Офицеруудын ордон хүртэл/ Сансарын тунелын 2 талын цэцэрлэг Цагдаагийн академийн гудамж Жуковын хөшөө орчим Дандарын гудамж Пусаны гудамж Зүүн 4 замаас дээш Туул Жинпаны аюулгүйн тойрог Эвтэй 4 амьтан дуустал Амгалангийн зам /Тролейбусны эцсээс Улиастайн гүүр хүртэл/ Токиогийн гудамж	Далайн цалгиа Төрийн бус байгууллага, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл, цэцэрлэгжилтийн мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг

	Сүхбаатар дүүрэг	
1.	Энхтайваны өргөн чөлөө /Төв шуудангаас Арслантай гүүр хүртэл/	
2.	Турк- Монголын найрамдал цэцэрлэг	
3.	Баруун цэцэрлэг /Энхтайваны хонхтой сад/	
4.	Шангриллагийн өмнөх цэцэрлэг	
5.	Сөүлийн гудамж /АН-ын байрнаас ТБД андуудын урд уулзвар хүртэл/	
6.	Циркийн арын талбай	
7.	Их сургуулийн гудамж	
8.	Холбоочдын сквер/ Төв шуудангийн өмнөх /	
9.	Бага тойруу /МУБИСургуулиас СУИС хүртэл/	
10.	Партизаны гудамж	
11.	Чоймболын гудамж	
12.	Нэгдсэн Үндэстний гудамж	
13.	Намнансүрэнгийн гудамж	
14.	Хувьсгалчдын цэцэрлэг /ЗГ-ын ордны ард/	
15.	Эрхүүгийн гудамж	
16.	Денверийн гудамж	
17.	Энэтхэг элчингийн орчим	
18.	Бээжингийн гудамж	
19.	Залуучуудын гудамж	
20.	Сүхбаатарын гудамж	
21.	Амарын гудамж	
22.	Зоригийн гудамж	
23.	Их тойруугийн гудамж /Баруун 4 замаас хойш 100 айлын Сэлбийн гүүр хүртэл/	
24.	Монгол эх цогцолбор	
25.	Нарны гүүрийн 2 тохой	
26.	Ногоон нуурын гудамж /Өлзий төвийн уулзвараас хойш 32-ын тойрог хүртэл/	
27.	32-ын тойргоос 7 буудлын эцэс хүртэл зам дагуу	
28.	/Чингэлтэйн гудамж/	
29.	Элчингийн гудамж	
30.	Сэлбэ гол дагуух цэцэрлэгжилт Арслантай гүүрээс хойш Сэлбийн баруун тал	
	Хан-Уул дүүрэг	
1.	Махатма Гандигийн гудамж	
2.	Нийслэл хүрээ өргөн чөлөө / Стадионы урдуурх гудамж /	
3.	Хүннү хороололын арын гудамж	
4.	То вангийн гудамж	
5.	Шаравын гудамж	
6.	Төртогтохын гудамж	
7.	3-р байрны арын бичил цэцэрлэг	
8.	4-р байрны өмнөх бичил цэцэрлэг	
9.	5 бичил цэцэрлэг /120 мянгат, Соёлын ордон орчмын ногоон байгууламж бүхий талбайнууд/	
10.	Шинэ Хан-уул цэцэрлэг	
11.	ХААИС-ийн зүүн гудамж	
12.	Гурвалжингийн гүүрний урд талын тусгаарлах зурвас	
13.	Гурвалжингийн гүүрийн зүүн урд тохой	
14.	Ажилчны гудамж /3-р цахилгаан станц орчим/	
15.	NTV телевизийн өмнөх гудамж	
16.	Энхтайваны гүүрний урд талын баруун, зүүн тохой /шинэ зам дагууд/	
17.	Оргил сувилалын арын гудамж	

	Баянгол дүүрэг	
1.	Энхтайваны өргөн чөлөө /Баруун 4 замын уулзвараас Саппорогийн уулзвар хүртэл/	Мөнх ногоон хэрэм хөдөлгөөн Төрийн бус байгууллага, Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл, цэцэрлэгжилтийн мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг
2.	Чингүнжавын гудамж	
3.	Энэбишийн өргөн чөлөө	
4.	Ард Аюушийн өргөн чөлөө	
5.	Магсаржавын гудамж	
6.	Вокзалын арын зүүн цэцэрлэг	
7.	Вокзалын арын баруун цэцэрлэг	
8.	1-р хорооллын эцсийн хос гүүрний баруун урд цэцэрлэг	
9.	Занабазарын гудамж	
10.	Амарсанаагийн гудамж	
11.	Хасбаатарын гудамж	
12.	Гурвалжингийн гүүрний хойд талын тусгаарлах зурвас	
13.	Замчны 1.2-р гудамж	
14.	Төмөр замын цагдаагийн хэлтэстэй гудамж	
15.	Жасрайн гудамж	
	б. Чингэлтэй дүүрэг	
1.	Энхтайваны өргөн чөлөө /Төв шуудангаас Баруун 4 замын уулзвар хүртэл/	
2.	Жуулчны гудамж	
3.	Асашёрюүгийн цэцэрлэг	
4.	Самбуугийн гудамж	
5.	Хувьсгалчдын гудамж	
6.	Учралын цэцэрлэг	
7.	Явуугийн цэцэрлэг	
8.	Бага тойруу /Цэцэг төвөөс УБ банкны уулзвар хүртэл/	
9.	Анкарагийн гудамж	
10.	Төмөрчний гудамж	
11.	Бэтүб хийдийн ар тал	
12.	Тасганы овооны зам дагууд	
13.	Тасганы овооны бичил цэцэрлэг	
14.	Ард кино театрын өмнөх талбай	
15.	Эрдэнэсийн арал	
	Сонгинохайрхан дүүрэг	
1.	Энхтайваны өргөн чөлөө /Саппорогоос 5 шарын баруун урд уулзвар хүртэл/	
2.	Залуус гудамж	
3.	Барилгачны гудамж	
4.	Сонсголлонгийн замын тусгаарлах зурвас	
5.	Үйлдвэрчний эвлэлийн гудамжны бичил цэцэрлэг	
6.	Үйлдвэрчний Эвлэлийн гудамж	
7.	22-ын товчооны замын тусгаарлах зурвас	
	Бүгд – 117 гудамж	
	Бусад гудамж, цэцэрлэгүүд	Нийслэлийн ногоон байгууламжийн иргэний зөвлөл, Далайн цалгиа, Мөнх ногоон хэрэм хөдөлгөөн Төрийн бус байгууллага,

Тайлбар: Тооллогын явцад жагсаалтанд ороогүй нэмэлтээр тоологдсон газруудыг бусад гудамж, цэцэрлэгүүд гэсэн бүлэгт нэр өгч оруулна.